



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/80

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгүүд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн авто замын сангийн 50,000,000(Тавин сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онд Тариалан сумын төвд 2,1 км авто зам барих ажлын худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, хэрэгжүүлэх, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрхийг Тариалан сумын Засаг даргад, шилжүүлсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийн мэдээллийг “Захиалагчийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тухай тайлан” маягтын дагуу сар бүрийн 5-ны өдрийн дотор аймгийн Орон нутгийн өмчийн газарт тогтмол ирүүлэхийг Тариалан сумын Засаг дарга (Ц.Хөвсгөлдалай)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД